



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар

# САНХҮҮГИЙН АУДИТЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СБА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Баруун-Урт сум 2023 он



Дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: Boldbaatarn@audit.gov.mn

Аудитор Б.Мөнхбамбар

Утас: 70512127 Цахим хаяг: Munkhbambarb@audit.gov.mn

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт .....	2
<b>ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ</b> .....	2
1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	8
3.1. Аудитын тайлан .....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 <i>Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт</i> .....	11
3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	11
3.5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн .....	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	12
3.5.2 Авлага .....	13
3.5.3 Бараа материал .....	14
3.5.4 Урьдчилгаа .....	15
3.5.5 Үндсэн хөрөнгө .....	16
3.5.6 Өр төлбөр .....	17
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо .....	19
3.5.8 Орлогын данс .....	19
3.5.9 Зардал .....	20
3.6 Нэмэлт санхүүжилт: .....	21
3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	22
3.8 Зөрчил дутагдлыг нэгж бүрээр нь авч үзвэл .....	23
3.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	24
3.10 Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авч үзсэн асуудал ...	24
3.10.1 Нягтлан бодох бүртгэл, тайлагнал .....	24
3.10.2 Төсвийн бодлогын хэрэгжилт, гүйцэтгэл .....	25
3.10.3 Санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх нийцлийн аудитын зарим асуудал .....	26
3.10.4 Аудитын явцад анхаарах бусад асуудал .....	27
3.11. Шилэн дансны мэдээлэл .....	28
3.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	29
3.13. Аудитын зөвлөмж .....	29
<b>САНАЛ:</b> .....	30
3.14. Холбогдох байгууллагын санал: .....	31
3.15. Аудитын тайлан баталгаажуулсан тушаал: .....	33
3.16. ХҮРГҮҮЛСЭН АЛБАН ШААРДЛАГА .....	35

Хавсралтууд..... 0

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын засгийн газар
НА	Нийцлийн аудит
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СБА	Сүхбаатар аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УОО	Урьдчилж орсон орлого
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт №2	Авлагын үлдэгдэл
Хүснэгт №3	Бараа материалын үлдэгдэл
Хүснэгт №4	Урьдчилгаа дансны үлдэгдэл
Хүснэгт № 5	Үндсэн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт № 6	Нийт өр төлбөрийн үлдэгдэл
Хүснэгт №7	Шинээр бүртгэгдсэн хойшлогдсон дансны үлдэгдэл
Хүснэгт № 8	Засгийн газрын оролцоо
Хүснэгт №9	Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт№10	Зардлын бүртгэл
Хүснэгт№11	Хязгаарлалттай дүгнэлт өгсөн байгууллагууд
Хүснэгт№12	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн, шийдвэрлэлт
Хүснэгт№13	Малын тоо толгойн татвар
Хүснэгт№14	Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт

## 1. Аудитын гэрчилгээ



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
М.ИДЭРБАТ ТАНАА

2023.05.03 № 219  
танай \_\_\_\_\_ - ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 13,816.4 сая төгрөгийн орлогоос Сангийн яам орон нутгийн төсөвт 9,637.2 сая төгрөгийг хуваарилж, үлдэгдэл 4,183.2 сая төгрөгийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, зээлийн хүүгийн төлбөрт суутган тооцсон байна.

### Аудитын гол асуудал

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл"-ийн хүрээнд "Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ"-ний ажил гүйцэтгэх дамжуулан зээлдүүлэх гэрээний ашиглалтын зардал 2,110.3 сая төгрөг болон валютын ханшийн тэгшитгэлийн зөрүү нэмэгдэж, 5,944.9 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй болсон байна.

### Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 сарын 03 өдрийн 02 тогтоолоор аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг баталсан бөгөөд биелэлт 88.5 хувьтай байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
		/мянган төгрөг/	
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	32,468,217.50	34,801,911.20
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	16,144,818.80	14,816,996.80
33	<b>АВЛАГА</b>	7,205,512.20	5,108,126.50
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	175,450.20	384,661.70
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8,814,593.40	3,375,560.00
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	14,172.70	48,377.00
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	113,670.30	11,068,189.20
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	122,232,469.90	63,259,470.50
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	122,232,469.90	63,259,470.50
39200	Биет хөрөнгө	117,599,594.70	58,238,088.40
39300	Биет бус хөрөнгө	4,622,684.90	5,013,496.80
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	10,190.30	7,885.30
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	154,700,687.40	98,061,381.70
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	29,661,928.00	28,615,821.20
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	22,370,288.90	20,865,899.00
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,109,940.40	884,284.10
41300	Өглөг	1,873,336.90	1,435,415.40
41400	Урьдчилж орсон орлого	19,387,011.60	18,546,199.50
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,291,639.10	7,749,922.20
42200	Урт хугацаат зээл	7,291,639.10	7,749,922.20
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	125,038,759.50	69,445,560.50
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	125,038,759.50	69,445,560.50
51100	Засгийн газрын оруулсан капитал	59,804,658.30	33,043,809.80
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,006,066.30	1,007,311.90
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	820.3	0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	236,956.00	236,956.00
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	38,997,199.40	25,083,731.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,993,059.30	10,073,751.90
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	154,700,687.40	98,061,381.70

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
		/мянган төгрөг/	
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	213,344,285.90	91,984,571.90
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	14,090,451.90	24,116,122.00
110	<b>Орлогын албан татвар</b>	8,425,862.00	18,256,015.70
1100	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	8,783,258.90	9,068,977.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-357,396.80	-450,203.30
1103	ААН-ын орлогын албан татвар	0	9,637,241.30
113	Хөрөнгийн албан татвар	2,823,608.60	2,385,775.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,840,981.30	3,474,331.20
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	100,798,893.70	44,918,400.60
120	Нийтлэг татварын бус орлого	42,637,086.60	26,390,879.20
121	Хөрөнгийн орлого	52,854.40	0

122	Тусламжийн орлого	38,300.00	4,200.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	58,070,652.70	18,523,321.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	98,454,940.40	22,950,049.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	169,382,290.30	63,989,410.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	169,382,290.30	63,273,932.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,081,659.10	61,863,300.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,841,310.40	8,770,969.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,499,422.80	1,088,054.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,399,360.80	5,878,497.40
2104	Хангамж, бараа материалын зардал	9,196,482.60	21,618,256.60
2105	Нормативт зардал	3,105,949.80	349,175.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	972,416.60	1,190,245.60
2107	Томилолт, зочны зардал	126,702.60	245,062.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,716,003.30	10,776,159.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,224,010.40	11,946,879.40
212	ТАТААС	245,233.80	330,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,055,397.40	1,080,632.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	715,477.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	43,961,995.60	27,995,161.20
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	500	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,426,815.70	85,488,210.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	26,535,679.90	-57,493,049.00

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,464,278.50	98,464,278.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	142,569.00	142,569.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,606,847.40	98,606,847.40
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-137,717.60	-137,717.60
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	12,784.00	12,784.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	21,165.80	21,165.80
9	Тайлант үеийн үр дүн	26,535,679.90	26,535,679.90
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,038,759.50	125,038,759.50
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	125,038,759.50	125,038,759.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,907,129.90	1,907,129.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,945,889.40	126,945,889.40
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-20,803.70	-20,803.70
17	Өмчид гарсан өөрчилөлт	11,620.00	11,620.00
19	Тайлант үеийн үр дүн	-57,493,049.00	-57,493,049.00
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	69,445,560.50	69,445,560.50

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	196,297,666.4	94,165,512.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	14,090,451.9	28,294,758.0

110	Орлогын албан татвар	8,425,862.0	22,434,651.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	8,783,258.9	9,068,467.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-357,396.8	-450,203.3
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	13,816,388.0
113	Хөрөнгийн албан татвар	2,823,608.6	2,385,775.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,840,981.3	3,474,331.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	376,840.5	310,750.6
1181	Газрын төлбөр	706,056.7	1,113,651.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,725,336.0	2,025,512.3
1183	Бусад татвар	32,748.0	24,417.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,527,335.5	42,411,453.1
120	Нийтлэг татварын бус орлого	26,400,528.4	23,811,515.1
121	Хөрөнгийн орлого	52,854.4	73,616.6
122	Тусламжийн орлого	3,300.0	3,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	58,070,652.7	18,523,321.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,679,879.0	23,459,301.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	164,084,432.5	49,653,465.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	164,084,432.5	49,653,465.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,054,095.6	48,189,176.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,600,215.8	12,481,811.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,435,117.0	2,151,448.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,489,948.9	6,939,014.7
2104	Хангамж, бараа материалын зардал	7,149,044.4	7,733,978.0
2105	Нормативт зардал	2,793,399.8	379,090.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,051,019.6	1,152,363.8
2107	Томиллолт, зочны зардал	129,686.4	243,586.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,393,880.6	7,365,496.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,011,783.2	9,742,387.0
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	245,233.8	330,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,785,103.1	1,134,288.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	32,213,233.8	44,512,047.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	19,682.6	15,346.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	24,623,762.7	40,990,490.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,623,762.7	40,990,490.4
2200	Дотоод эх үүсвэрээр	24,623,762.7	40,990,490.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-24,604,080.1	-40,975,144.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-872,636.4	-4,864,725.2
14	Бусад эх үүсвэр	19,045.2	15,154.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	854,568.0	4,855,146.7
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	37,113.6	24,732.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,736,517.3	-1,327,822.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,408,301.6	16,144,818.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,144,818.8	14,816,996.8

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	59,926,734.70	50,520,084.10
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	33,249,236.00	30,041,316.20
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	31,889,662.00	28,855,042.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,380,862.00	8,025,069.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,047,930.50	998,960.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,707,809.10	6,038,927.30
2104	Хангамж, бараа материалын зардал	736,057.00	701,386.50
2105	Нормативт зардал	17,012.70	14,250.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,529,408.90	1,396,214.60
2107	Томилолт, зочны зардал	244,239.00	219,668.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,085,974.10	3,917,591.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,140,368.70	7,542,973.10
212	<b>ТАТААС</b>	437,233.80	330,000.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	107,233.80	0.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	330,000.00	330,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	922,340.20	856,274.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	922,340.20	856,274.20
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	24,443,715.50	19,802,767.90
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	2,233,783.20	676,000.00
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	59,926,734.70	47,358,454.40
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,058,682.20	11,832,549.60
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,708,789.60	32,898,930.90
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	10,159,262.90	2,626,973.90
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	6,781,360.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	3,577,222.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны Гүйцэтгэл	Тайлант оны Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	6,693,455.60	2,194,246.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	6,693,455.60	2,194,246.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5,907,937.00	1,810,279.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,168.80	25,369.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,986.9	2,694.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,161.30	33,147.30
2104	Хангамж, бараа материалын зардал	291,216.40	61,627.90
2105	Нормативт зардал	1,007,932.40	3,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	436,832.70	51,691.40
2107	Томилолт, зочны зардал	5,977.20	12,210.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,574,821.00	636,412.10

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,749,840.30	984,016.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	785,518.60	383,966.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	577,685.00	577,685.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	170,563.60
2200	Дотоод эх үүсвэрээр	-	213,402.60
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	6,748,734.50	2,138,967.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,748,734.50	2,138,967.10
	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	55,278.90	-55,278.90
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	55,278.90	55,278.90



### 3.1. Аудитын тайлан

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга М.Идэрбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн урт хугацаат өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, санхүүгийн тайланд тохируулга хийж, баланс тайланд өр төлбөрийг үнэн зөв илэрхийлэх, санхүүгийн тайлан, тодруулгын иж бүрдлийг хангаж толилуулахад нягтлан бодогчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх орлогын биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2023 оны 4 дүгээр сарын 01-нээс 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Б.Мөнхбамбар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2023.03.31-нд төрийн аудитын байгууллагад 05/114 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Мэдлэгт суурилсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл тээвэр логистикийн хөгжлийн тулгуур төв болох”-д оршино.

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 сарын 03 өдрийн 02 тогтоолоор аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг баталсан бөгөөд биелэлт 88.5 хувьтай байна.

Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого 7 арга хэмжээ
- Хүний хөгжил 125 арга хэмжээ
- Эдийн засаг 116 арга хэмжээ
- Засаглал 59 арга хэмжээ
- Байгаль орчин, ногоон хөгжил 31 арга хэмжээ
- Бүс, орон нутгийн хөгжил 27 арга хэмжээ

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Сангийн сайдын 2022 оны 33 дугаар тушаал “Дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг суутган тооцох тухай”
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2009 онд боловсруулсан, нэмэлт өөрчлөлт, стандартын өөрчлөлттэй холбогдуулан шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад заавар, журам, стандартыг мөрдөхгүй байх зэрэг үр дагавартай байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг үр нөлөө төлөвлөлтөөс зөрүүгүй байна гэж үзлээ.

Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 2022 онд Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу 2016-2020 оны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг тогтоох, арилгахаар, мөн 2020-2021 оны цахилгаан, ус дулааны хөнгөлөлтөд тус тус шалгалт хийсэн байна.

Аймгийн Засаг даргын харьяа төсвийн шууд захирагч, ОНӨААТҮГ-ын нийт 40 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, 10 объектын үйл ажиллагаанд дотоод аудит, иргэний 11 өргөдлийн дагуу санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэжээ.

Хяналт шалгалтаар нийт 1,900.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 187.9 сая төгрөгийн 36 акт тогтоож, 1,712.3 сая төгрөгийн 38 албан шаардлага өгсөн байна. Төлбөрийн актын биелэлт 79.5 хувь, албан шаардлагын биелэлт 94.7 хувьтай байна.

### **3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг аймгийн Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 64,014.2 сая төгрөгийн 1.5 хувь буюу 960.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь болох 720.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн**

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 16,144.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 14,817.0 сая төгрөг болж, 1,327.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	/сая төгрөг/			
	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө		7.5	4.7	-2.9
Банканд байгаа бэлэн мөнгө		16,137.3	14,812.3	-1,325.0
Дүн		<b>16,144.8</b>	<b>14,817.0</b>	<b>-1,327.8</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>				
Төсөвт байгууллага		6,836.6	3,577.2	-3,254.4
Төсөл/ сан		3,459.6	3,390.9	-68.7
Төрийн сан		5,443.4	6,543.5	1,100.1
ТӨҮГ болон ОНӨҮГ		405.2	1,305.4	900.2
Дүн		<b>16,144.8</b>	<b>14,817.0</b>	<b>-1,327.8</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 3,577.2 сая төгрөг төсөвт байгууллага, 3,390.9 сая төгрөг төсөл сангийн үлдэгдэл, 1,305.4 сая төгрөг орон нутгийн өмчит байгууллага, 6,543.5 сая төгрөг Төрийн сангийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн дансны үлдэгдлийн 6,543.5 сая төгрөгийн 6,382.6 сая төгрөг орон нутгийн ерөнхий дансны үлдэгдэл, 160.9 сая төгрөг нэмэлт дансны үлдэгдэл байна. Харин төсөвт байгууллагын үлдэгдэл 3,577.2 сая төгрөг байгаа ба 1,640.6 сая төгрөг Орон нутгийн хөгжлийн сан, 246.4 сая төгрөг Замын сан, Боловсрол, эрүүл мэндийг дэмжих сангийн үлдэгдэл 1,494.0 сая төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл, 196.2 сая төгрөг барилга, техникийн хяналт дансны үлдэгдэл байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 1,940.7 сая, газрын дуудлага худалдааны орлого 795.3 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөр 890.1 сая, шууд бус орлого 88.2 сая нийт 3,714.3 сая төгрөгөөр орлого давсан нь төрийн сангийн дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудад нийт 3,971.8 сая төгрөгийн 122 алдаа, зөрчил илэрч 64.5 сая төгрөгийн зөрчилд 24 төлбөрийн акт тогтоож, 3,827.3 сая төгрөгийн зөрчилд 54 албан шаардлага, 80.0 сая төгрөгийн 44 зөвлөмж өглөө. Үүнд:

- Төсөл, арга хэмжээний ажлыг зураг төсөлгүй гүйцэтгэсэн /Баяндэлгэр, Түвшинширээ, Сүхбаатар сумын Орон нутгийн хөгжлийн сан, аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Байгаль орчин аялал жуулчлалын газар-878.0 сая төгрөг/
- Албан томилолтыг удирдамж боловсруулаагүй төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон. /Түмэнцөгт, Уулбаян, Дарьганга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Уулбаян, Сүхбаатар, Дарьганга сумын Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар/
- Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт байхгүйгээр ажил гүйлгээ хийсэн. /Наран, Онгон, Дарьганга, Түмэнцөгт, Баруун-Урт, Уулбаян сумдын Орон нутгийн хөгжлийн сан, Мөнххаан, Эрдэнэцагаан, Баруун-Урт, Түвшинширээ, аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1,251.2 сая төгрөг/
- Баяр наадмын талбай шинээр барих ажлын захиалагчийн хяналт хийгдээгүй байхад гүйцэтгэгч компанид санхүүжилт илүү олгогдсон. /Эрдэнэцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сан 4.8 сая төгрөг/

- Тендер сонгон шалгаруулалгүй шууд гэрээ байгуулсан. /Халзан дулаан ОНӨААТҮГ 31.9 сая төгрөг/
- Цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал буруу тооцож, олгосон /Асгат, Түмэнцогт, Уулбаян сумыг Засаг даргын тамгын газар, Дарьганга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Орон нутгийн өмчийн газар, Уртын гэгээ ОНӨААТҮГ, Чоногол хөгжил ОНӨААТҮГ, Бичигт хөгжил ОНӨААТҮГ/

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 7,143.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,108.1 сая төгрөг болж, 2,035.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл		/ сая төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	29.9	2.3	-27.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	125.9	456.8	330.9
Татаас, санхүүжилтийн авлага	18.1	9.3	-8.8
Зээлийн хүүгийн авлага	48.3	71.6	23.3
Дансны авлага /ТӨҮГ/	2,304.5	1,396.3	908.2
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	37.8	58.3	20.5
Бусад авлага	4,324.7	2,891.1	-1,433.6
Зээлийн авлага	254.7	222.4	-32.3
Дүн	<b>7,143.9</b>	<b>5,108.1</b>	<b>-2,035.8</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	4,172.4	3,249.2	-923.2
Төсөл/ сан			
Төрийн сан	97.2	243.7	146.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,874.3	1,615.2	-1,259.1
Дүн	<b>7,143.9</b>	<b>5,108.1</b>	<b>-2,035.8</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 63.6 хувь буюу 3,249.2 сая төгрөг төсөвт байгууллагын, 31.6 хувь буюу 1,615.2 сая төгрөг орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 4.8 хувь буюу 243.7 сая төгрөг төрийн сангийн авлага байна.

Төсөвт байгууллагын нийт авлагын 78.7 хувийг хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага, 10.5 хувийг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор гэрээний дагуу олгосон зээлийн авлага байна. Энэ нь өмнөх санхүүгийн тайлангаар өгсөн зөвлөмжийн дагуу авлагыг бүртгэлд тусгажээ. Мөн тайлант онд шинээр хоршоо хөгжүүлэх сангаас 676.0 сая төгрөгийн зээл олгосон нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд нийт авлагын 35.8 хувийг эзэлж байгаа буюу 577.7 сая төгрөг Сүхбаатар үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ-ын зээлийн авлага, 51.9 хувь буюу 838.8 сая төгрөг Дөрвөлж ОНӨААТҮГ-ын авлага эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт:

Авлагатай холбоотой аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудад нийт 244.2 сая төгрөгийн 16 алдаа, зөрчил илэрч 2.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 158.9 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 82.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өглөө. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн зээлийн гэрээний хугацаа дууссан боловч зээлийн үндсэн төлөлт, хүүгийн орлогыг гэрээнд заасан хугацаанд төлж

барагдуулаагүй /Мөнххаан, Асгат, Дарьганга, Түмэнцогт, Онгон, Эрдэнэцагаан сумын хоршоо хөгжүүлэх сангийн-212.5 сая төгрөг /

- Зээлийн гэрээний хугацаа дууссан боловч хариуцагч нас барсантай холбоотойгоор зээлийг төлж барагдуулаагүй байна. /Уулбаян сумын хоршоо хөгжүүлэх сан-4.1 сая төгрөг/
- Харилцагч, бэлтгэн нийдүүлэгч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй авлагыг тайланд тусгасан /Баруунурт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ, Уртын гэгээ ОНӨААТҮГ/

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын оны эхний үлдэгдэл 8,814.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,375.5 сая төгрөг болж, 5,439.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	766.7	403.3	-363.4
Дуусаагүй үйлдвэрлэл	269.2	281.9	12.7
Бэлэн бүтээгдэхүүн	8.5	6.5	-2.0
Хангамжийн материал	4,703.1	2,103.2	-2,599.9
Биологийн хөрөнгө	2,672.9	20.0	-2,652.9
Мал амьтад	394.2	560.6	166.4
<b>Дүн</b>	<b>8,814.6</b>	<b>3,375.5</b>	<b>-5,439.1</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			0.0
Төсөвт байгууллага	7,842.7	2,256.4	-5,586.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	971.9	1,119.1	147.2
<b>Дүн</b>	<b>8,814.6</b>	<b>3,375.5</b>	<b>-5,439.1</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 7,978.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, үнэ төлбөргүй буюу хандиваар 208.2 сая, шилжүүлэн авсан 576.4 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 8,094.1 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 2,779.3 сая төгрөгийг данс хооронд шилжүүлж, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага харьяа дээд шатны төсвийн захирагчид хамаарах болсноор 3,332.1 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн тайланд шилжүүлсэн байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 66.8 хувийг төсөвт байгууллага, 33.2 хувийг ОНӨААТҮГ эзэлж байна.

Бараа материалын дуусаагүй үйлдвэрлэл дансанд, Баруун-Урт сумын ОНХС-аар хэрэгжиж дуусаагүй 4 төсөл арга хэмжээний 202.5 сая төгрөг, Онгон сум зам засварын гэрэлтүүлэг, хөдөөгийн багт худаг гаргах 2 төсөл арга хэмжээний 79.3 сая төгрөгийг тус тус бүртгэсэн байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд биологийн хөрөнгөнд үлдэгдлээр бүртгэлтэй байсан 4 төсөл арга хэмжээний 2,312.6 сая төгрөгийг шилжүүлэн бүртгэж, мөн тухайн онд аймаг, сумын ОНХС-аар хэрэгжиж бүрэн санхүүжигдээгүй 18 төсөл арга хэмжээний 8,687.2 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Бараа материалын мал амьтадын дансны үлдэгдэл 560.6 сая төгрөг байгаа нь тусгай зориулалтын байгууллагын 126.4 сая төгрөгийг шилжүүлж, малын үйлдвэр угсааг сайжруулахаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар 340.7 сая төгрөгөөр эцэг мал худалдан авсан нь нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

Бараа материалтай холбоотой нийт 71.4 сая төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрч 54.8 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 16.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өглөө. Үүнд:

- Бараа материалын тайланг сар бүр гаргадаггүй, хөрөнгийн тооллогыг Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу үнэн зөв толилуулж, тайлагнаагүй байна. /Бичигт их өргөө, Чоногол хөгжил, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ 16.6 сая төгрөг/
- Орон нутгийн хөгжлийн сангаар малын тэжээл, өвс худалдан авч бүртгэл тусгаагүй /Наран сумын орон нутгийн хөгжлийн сан 50.4 сая төгрөг/

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 175.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 384.7 сая төгрөг болж, 209.3 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл**

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Урьдчилж гарсан зардал</b>	150.5	364.4	213.9
<b>Бараа материал бэлтгэх урьдчилгаа</b>	24.9	20.3	-4.6
<b>Цалингийн урьдчилгаа</b>	0	0	0
Дүн	<b>175.4</b>	<b>384.7</b>	<b>209.3</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
<b>Төсөвт байгууллага</b>	<b>0.0</b>	<b>0.3</b>	<b>0.3</b>
<b>ТӨҮГ болон ОНӨҮГ</b>	<b>175.4</b>	<b>384.4</b>	<b>209.0</b>
Дүн	<b>175.4</b>	<b>384.7</b>	<b>209.3</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Баруунурт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ хуучин наадмын талбайн 1.4 га-д тарих зүлгийн бордооны үнэ 20.0 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн байна.

Урьдчилж гарсан зардалд Дөрвөлж ОНӨААТҮГ шугам сүлжээний ажил болон нүүрс, шатахууны картын үлдэгдэл 352.9 сая, Сүхбаатар тохижилт ОНӨААТҮГ хөрөнгө бэлтгэхэд 10.5 сая төгрөгийг бэлтгэн нийлүүлэгчид төлсөн нь гол нөлөөлөл үзүүлжээ.

**Аудитын илрүүлэлт:**

Бараа материалтай холбоотой нийт 184.3 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрч 184.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

- Тайлант онд төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид банкны баталгаагүйгээр урьдчилгаа олгосон байна. /Асгат, Мөнххаан сумын орон нутгийн хөгжлийн сан 184.3 сая төгрөг/

### 3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 122,232.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 63,259.25 сая төгрөг болж, 58,973.25 сая төгрөгөөр буурсан байна.

<i>Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл</i>			
	<i>/сая төгрөг/</i>		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	101,857.10	46,402.70	-55,454.40
Хуримтлагдсан элэгдэл	-13,889.50	-12,020.50	1,869.00
Тээврийн хэрэгсэл	8,420.30	7,999.60	-420.70
Хуримтлагдсан элэгдэл	-5,191.30	-4,235.20	956.10
Машин тоног төхөөрөмж	18,886.90	11,742.20	-7,144.70
Хуримтлагдсан элэгдэл	-11,339.80	-6,095.70	5,244.10
Тавилга эд хогшил	6,505.90	2,050.20	-4,455.70
Хуримтлагдсан элэгдэл	-4,444.70	-1,257.30	3,187.40
Зам гүүрийн байгууламж	767.8	754.8	-13.00
Хуримтлагдсан элэгдэл	-68.8	-99.4	-30.60
Түүх соёлын дурсгалт зүйл	1,174.60	0.02	-1,174.58
Дуусаагүй барилга байгууламж	2,424.50	916.80	-1,507.70
Номын фонд	792.7	0.43	-792.27
Бусад үндсэн хөрөнгө	20,308.20	20,625.10	316.90
Хуримтлагдсан элэгдэл	-8,604.10	-8,545.60	58.50
Программ хангамж	116.6	106.7	-9.90
Хуримтлагдсан элэгдэл	-73.7	-26	47.70
Бусад биет бус хөрөнгө	4,591.70	4,936.90	345.20
Хуримтлагдсан элэгдэл	-12	-4.3	7.70
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	10.1	7.8	-2.30
<b>Дүн</b>	<b>122,232.50</b>	<b>63,259.25</b>	<b>-58,973.25</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	88,921.40	30,553.70	-58,367.70
ТӨҮГ болон ОНӨҮГ	33,311.10	32,705.70	-605.4
<b>Дүн</b>	<b>122,232.50</b>	<b>63,259.50</b>	<b>-58,973.10</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 48.3 хувь орон нутгийн төсөвт байгууллагууд, 51.7 хувь ОНӨААТҮГ-ын хөрөнгүүд эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,108.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,838.8 сая, шилжүүлэн авсан 2,723.5 сая, бусад 4,930.9 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 871.3 сая нийт 11,472.9 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 569.0 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 78,665.3 сая, акталсан 1,864.5 сая, бусад 670.8 сая, дахин үнэлгээний хорогдол 16.2 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга байгууламж данснаас Биеийн тамир спортын газрын 700 хүний 1,602.5 сая төгрөгийн Спорт цогцолборын барилгыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж, Наран сумын ахуй үйлчилгээний төвийн засварын 94.8 сая төгрөгийг хөрөнгийг шинээр бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 348.4 сая төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлснээс 336.3 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 12.1 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. /Мөнххаан, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумын Засаг даргын тамгын газрууд-308.0 сая төгрөг/
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хийгдсэн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй, ашиглагч байгууллагад шилжүүлэх, бүртгэлээр тавих хяналт хэрэгжээгүй. /Байгаль орчин аялал жуулчлалын газар/
- Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй. /Халзан, Дарьганга сумын Засаг даргын тамгын газар, Чоногол хөгжил ОНӨААТҮГ/

### 3.5.6 Өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 22,308.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 20,865.9 сая төгрөг болж, 1,442.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>22,308.6</b>	<b>20,865.9</b>	<b>-1,442.7</b>
<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	<b>1,109.9</b>	<b>884.3</b>	<b>-225.6</b>
Өглөг	1,811.7	1,435.4	-376.3
<b>Ажиллагчидтай холбогдсон өглөг</b>	116.9	69.1	-47.8
<b>Бараа үйлчилгээний зардлын өглөг</b>	64.5	0	-64.5
<b>Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг</b>			0
Бусад өглөг	1,630.3	1,366.3	-264.0
<b>Байгууллагад төлөх өглөг</b>	1,285.9	1,112.4	-173.5
<b>Хувь хүмүүст төлөх өглөг</b>	48.1	42.2	-5.9
<b>Татварын өглөг /ТӨҮГ/</b>	190.6	99.1	-91.5
<b>НДШ-ийн өглөг /ТӨҮГ/</b>	25.6	24.0	-1.6
<b>Дансны өглөг /ТӨҮГ/</b>	80.1	88.6	8.5
Урьдчилж орсон орлого	19,387.0	18,546.2	-840.8
<b>Бусад урьдчилж орсон орлого</b>	18,710.4	17,856.0	-854.4
<b>ТӨҮААГ</b>	676.6	690.2	13.6
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>7,291.6</b>	<b>6,812.9</b>	<b>478.7</b>
<b>Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв</b>	7,291.6	6,812.9	-478.7
<b>Нийт дүн</b>	<b>29,600.2</b>	<b>27,678.8</b>	<b>-1,921.4</b>
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>22,308.6</b>	<b>20,865.9</b>	<b>-1,442.7</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	682.2	602.4	-79.8
Төрийн сан	218.1	307.6	89.5

ТӨҮГ болон ОНӨҮГ	21,408.3	19,955.9	-1,452.4
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>	<b>7,291.6</b>	<b>6,812.9</b>	<b>-478.7</b>
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,394.0	1,805.0	-2,589.0
<b>Төсөвт байгууллага</b>	<b>2,897.6</b>	<b>5,007.9</b>	<b>2,110.3</b>
Нийт дүн	<b>29,600.2</b>	<b>27,678.8</b>	<b>-1,921.4</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн дүн 1,442.7 сая төгрөгөөр буурахад зээлийн өглөг 225.6 сая, өглөг 376.3 сая, урьдчилж орсон орлого 840.8 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Харин дансны өглөг /ТӨҮГ/ 8.5, ТӨҮГААГ 13.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөрийн 95.6 хувь буюу 19,955.9 сая төгрөг орон нутгийн өмчит хуулийн этгээд, 2.9 хувь буюу 602.4 сая төгрөг төсөвт байгууллагын, 1.5 хувь буюу 307.6 сая төгрөгийг төрийн сангийн өр төлбөр эзэлж байна.

Урьдчилж орсон орлого 840.8 сая төгрөгөөр буурсан нь ОНӨААТҮГ-т орон нутгийн өмчийг эзэмшүүлж, элэгдлээр нь орлогыг бууруулсан нь богино хугацаат өр төлбөрийг буурахад нөлөөлсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 14 ОНӨААН-тэй холбоотой 18,710.4 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэлтэйгээс тайлант онд 1,479.3 сая төгрөгийн орлогыг бууруулах бичилт хийгдэж, 4 байгууллагад 624.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэгдэж, оны эцэст 17,856.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Шинээр бүртгэгдсэн, хойшлогдсон орлогыг хүснэгтээр харуулбал.

<i>Хүснэгт №7 Шинээр бүртгэгдсэн хойшлогдсон орлого</i>		<i>/сая төгрөгөөр/</i>
Байгууллагын нэр	Дүн	
1 Онгон арвижих ОНӨААТҮГ		232.7
2 Түмэнцогт Ус дулаан ОНӨААТҮГ		364.1
3 Нийтлэг		15.3
4 Амгалант дэнж		12.8
Нийт дүн		624.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 7,291.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,749.9 сая төгрөг болж, 458.3 сая төгрөгөөр өсөхөд валютын ханшийн тэгшитгэлийн зөрүү нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд:

- Дөрвөлж ОНӨААТҮГ-ын Азийн хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн үлдэгдэл 4,394.0 сая төгрөгөөс 2,589.1 сая төгрөгийг барагдуулж, 1,805.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд “Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ”-ний ажил гүйцэтгэх дамжуулан зээлдүүлэх гэрээний ашиглалтын зардал 2,110.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 5,944.9 сая төгрөгийн өр төлбөр бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөртэй холбоотой нийт 49.8 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрч, 28.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 21.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өглөө. Үүнд:

- Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид санхүүжилт дутуу олгосонтой холбоотой өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна. /Уулбаян сумын орон нутгийн хөгжлийн сан 9.4 сая төгрөг/
- Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж, өр төлбөр үүсгэсэн /Түмэнцогт сумын Засаг даргын тамгын газар, Ерөнхийн боловсролын 4-р сургууль 22.8 сая төгрөг/
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр олгосон зээл, зээлийн хүүгийн авлага аймгийн төрийн санд төлөх өр төлбөртэй материаллаг зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа бөгөөд үлдэгдлийн баталгаагаар баталгаажгаагүй байна. /Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ/
- Өмнөх оны нүүрсний үнэ, тээврийн хөлсийг өглөгөөр тайлагнаагүйгээс орлого үр дүнгийн тайланд зардал илүү илэрхийлсэн. /Онгон арвижих ОНӨҮГ/

### 3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 125,038.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 69,445.5 сая төгрөг болж 55,593.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8 Засгийн газрын оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн +
			Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал	59,804.7	33,043.8	-26,760.9
Өмч /ТӨҮГ/	1,006.9	1,007.3	0.4
Эздийн өмчийн бусад хэсэг	236.9	236.9	0
Хуримтлагдсан үр дүн	38,997.2	25,083.7	-13,913.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,993.0	10,073.8	-14,919.2
<b>Дүн</b>	<b>125,038.7</b>	<b>69,445.5</b>	<b>-55,593.2</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	104,267.3	44,197.5	-60,069.8
Төсөл, сан	3,459.6	3,390.9	-68.7
Төрийн сан	5,322.5	6,479.6	1,157.1
<b>ТӨҮГ болон ОНӨҮГ</b>	<b>11,989.3</b>	<b>15,377.5</b>	<b>3,388.2</b>
<b>Дүн</b>	<b>125,038.7</b>	<b>69,445.5</b>	<b>-55,593.2</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь тайлант үеийн үр дүн нөлөөлжээ.

Тайлант онд тусгай шилжүүлгийн байгууллагыг дээд шатны төсөв захирагчид шилжүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын капитал 26,763.5 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 14,919.3 сая, хуримтлагдсан үр дүн 12,975.6 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5.8 Орлогын данс

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны орон нутгийн төсвийн татварын орлогыг 20,246.5 сая, татварын бус орлогыг 5,818.4 сая, хөрөнгийн орлогыг 50.0 сая нийт 26,114.9 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр татварын орлого 28,295.3 сая, татварын бус орлого 3,170.2 сая, хөрөнгийн орлого 73.6 сая нийт 31,539.1 сая төгрөг төвлөрчээ. Үүнээс татварын орлогын гүйцэтгэл 140 хувь, татварын бус орлого 54 хувь нийт дүнгээр 121 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Хүснэгт №9 Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	1	2	/2-1/	/2:1/
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>26,114.90</b>	<b>31,539.10</b>	<b>5,424.20</b>	<b>121</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>20,246.50</b>	<b>28,295.30</b>	<b>8,048.80</b>	<b>140</b>
Хүн амын орлогын албан татвар	7,658.00	8,618.80	960.80	113
ААН-ын орлогын албан татвар	7,696.50	13,816.40	6,119.90	180
Өмчийн татвар	2,491.00	1,871.60	-619.40	75
Дотоодын бараа ажил үйлчилгээний татвар	440.00	514.20	74.20	117
Бусад татвар /төлбөр хураамж/	1,961.00	3,474.30	1,513.30	177
Улсын тэмдэгтийн хураамж	140.90	147.20	6.30	104
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	203.60	152.30	-51.30	75
Газрын төлбөр	520.30	309.30	-211.00	59
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,040.00	2,025.50	985.50	195
Бусад татвар	-	24.40	24.40	-
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,818.40</b>	<b>3,170.20</b>	<b>-2,648.20</b>	<b>54</b>
Хүү, торгуулийн орлого	1,191.00	907.60	-283.40	76
Бусад орлого	4,627.40	2,262.60	-2,364.80	49
Хөрөнгө худалдсаны орлого	50.00	73.60	23.60	147

Татварын болон татварын бус орлогоос 7 төрлийн орлого 6.3-6,119.9 сая төгрөгөөр давж, 6 төрлийн орлого 51.3-2,648.2 сая төгрөгөөр тасарсан. **Татварын болон татварын бус орлогын давсан, тасарсан шалтгааныг Төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээс үзнэ үү.**

Аудитын илрүүлэлт:

Орлого данстай холбоотой нийт 603.9 сая төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрч, 23.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 580.2 сая төгрөгийн 13 зөрчилд зөвлөмж өглөө. Үүнд:

- Малчин болон мал бүхий иргэдээс малын тоо толгойд ногдуулсан татварыг дутуу төвлөрүүлсэн. /Бүх сумын Засаг дарга 580.2 сая төгрөг /
- Орон нутгийн төсвийн орлого нь тасарч, төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлтэй асуудал үүсэж байна /Түмэнцогт сумын Засаг дарга/

**3.5.9 Зардал**

Бараа үйлчилгээний зардал өмнөх оноос 26.4 хувь буюу 22,160.2 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 27.9 хувь буюу 2,791.8 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт №10 Зардлын гүйцэтгэл**

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өссөн +
----------	---------

	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Буурсан -
Бараа, ажил үйлчилгээний зардал	84,048.3	61,888.1	-22,160.2
Татаас	-	330.0	330.0
Урсгал шилжүүлэг	3,872.4	1,080.6	-2,791.8
<b>Дүн</b>	<b>87,920.7</b>	<b>63,298.7</b>	<b>-24,622.0</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	68,978.5	32,036.3	-36,924.8
Төсөл, сан	10,463.2	21,598.7	11,135.5
Төрийн сан	111.4	92.3	-19.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	8,367.6	9,571.4	1,186.4
<b>Дүн</b>	<b>87,920.7</b>	<b>63,298.7</b>	<b>-24,622.0</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа үйлчилгээний зардал буурсан нь тусгай зориулалтын байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр шилжсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаар тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2022 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 59,926.7 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 59,926.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 33,249.2 сая төгрөгийг урсгал зардалд, 24,443.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 2,233.8 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 12,058.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 37,708.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,159.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 11,832.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 32,989.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,627.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 3,070.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс нийт 50,520.1 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулж, орон нутгийн төсөвт 663.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.6 Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлээр ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 320.9, хандив тусламж 196.7, дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 818.8, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 802.6 сая нийт 2,139.0 сая төгрөгийг

зарцуулж, эрүүл мэндийн төвүүдийн тайланг орон нутагт нэгтгэхгүй болсонтой холбоотойгоор өмнөх оны үлдэгдэл 55.3 сая төгрөгийг холбогдох байгууллага руу шилжүүлэн, үлдэгдэл 158.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 25.4, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.7, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 33.1, хангамж, бараа материалын зардалд 61.6, нормативд зардалд 3.1, эд хогшил, урсгал засварын зардалд 51.7, томилолт, зочны зардалд 12.2, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 636.4, бараа үйлчилгээний бусад зардалд 984.0, урсгал шилжүүлэг 384.0 сая төгрөг нийт 2,194.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргасан.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 13 сумын Засаг дарга, 59 төсвийн байгууллага, 21 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нийт 93 санхүүгийн тайлан нэгтгэгдэж аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагаас 52 байгууллагыг түүвэрт хамруулж, 41 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: 40 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 1 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

#### Хүснэгт № 11 “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байгууллагууд

Д/Д	№	Аудитын код	Байгууллагын нэр
<b>ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД</b>			
1	1	СБА-2023/03/НА-СТА-ОНА	Бичигт хөгжил ОНӨААТҮГ

### **Аудитын илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой**

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа байгууллагуудад нийт 7,768.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,614.4 сая төгрөгийн алдааг залруулж, 67.0 сая төгрөгийн зөрчилд 26 төлбөрийн акт тогтоож, 4,613.8 сая төгрөгийн зөрчилд 78 албан шаардлага, 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 793.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 82 зөвлөмж өгсөн.

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн нийт 74,829.0 сая төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 47.9 сая төгрөгөөр эргэлтийн хөрөнгийн дүнг илүү, 21.6 сая төгрөгөөр эргэлтийн бус хөрөнгийг дутуу, 937.6 сая төгрөгөөр нийт өр төлбөрийг дутуу, 963.9 сая төгрөгөөр цэвэр хөрөнгө өмчийн дүн илүү нэгтгэсэн,
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 14.7 сая төгрөгөөр үйл ажиллагааны орлогын дүнг илүү, 2,108.9 сая төгрөгөөр үйл ажиллагааны зардлын дүнг илүү, үйл ажиллагааны бус зардлын дүн 3,077.0 сая төгрөгөөр дутуу, 982.8 сая төгрөгөөр үйл ажиллагааны нийт үр дүнг илүү нэгтгэсэн

- Мөнгөн гүйлгээний тайланд 31.7 сая төгрөгөөр үйл ажиллагааны мөнгөн орлогын дүнг илүү, 31.7 сая төгрөгөөр нийт зарлага ба цэвэр зээлийн дүн дутуу нэгтгэсэн,
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 65,620.3 сая төгрөгөөр нягтлан бодох бодлогын өөрчлөлтийг дутуу, 2.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт дутуу, 1.8 сая төгрөгөөр өмчид гарсан өөрчлөлт илүү, 987.0 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүнг дутуу тайлагнасан;

### 3.8 Зөрчил дутагдлыг нэгж бүрээр нь авч үзвэл

#### **Сүхбаатар аймгийн Засаг даргад хүргүүлсэн албан шаардлага**

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 74,829.0 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчил дутагдлыг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

#### **3.8.1 Албан шаардлага:**

##### **1. Шилэн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Шилэн дансанд мэдээлэх 8 төрлийн мэдээллийг 60 удаа хоцроосон, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага хүргүүлэх

##### **2. Төсөв батлахтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх нөхцөлтэй, хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг Аймгийн ИТХ-аар батлуулаагүй шийдвэрлэсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага хүргүүлэх

**Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:**

#### **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар**

Аудитаар нийт 603.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, 23.7 сая төгрөгийн зөрчлийн арилгах 2 албан шаардлага, 580.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 зөвлөмж өглөө.

#### **Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар**

Харьяа төсвийн 59 байгууллагаас 43 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 16 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,550.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 122.4 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 58.8 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт тогтоож, 4,172.8 сая төгрөгийн зөрчилд 59 албан шаардлага, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 196.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 48 зөвлөмж өглөө.

### **Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар**

Харьяа орон нутгийн өмчит 21 аж ахуйн нэгж байгууллагаас 9 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 11 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 1 байгууллагад “Хязгаарлалттай” /Бичигт хөгжил ОНӨААТҮГ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2,614.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,172.3 сая төгрөгийн алдааг залруулж, 8.2 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 417.3 сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага, 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 16.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 19 зөвлөмж өглөө.

### **3.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлант дараах анхаарал татахуйц асуудлууд байна.

- Дөрвөлж ОНӨААТҮГ-т улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд НББОУС-ын дагуу бүртгээгүйгээс тайлант жилийн ашиг алдагдалд нөлөөлж байна. Иймд өмнөх онуудад бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд хэрхэн бүртгэсэн байдлыг авч үзэх
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 13,816.4 сая төгрөг төвлөрөхөөс орон нутгийн төсөвт 9,637.2 сая төгрөгийг хуваарилж, үлдэгдэл 4,183.2 сая төгрөгийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, зээлийн хүүгийн төлбөрт аймгийн Засаг даргын албан тоотын дагуу суутган тооцсон байна. Урт хугацаатай зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөр, алдангийг санхүүгийн тайланд иж бүрэн тусгаагүй байна. Энэ талаар аудитын явцад залруулга хийсэн.

### **3.10 Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авч үзсэн асуудал**

#### **3.10.1 Нягтлан бодох бүртгэл, тайлагнал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээ аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2009 онд боловсруулсан, нэмэлт өөрчлөлт, стандартын өөрчлөлттэй холбогдуулан шинэчлэн боловсруулаагүй байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан бүрэлдэхүүн хэсгийн хангаж байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн тайланд ОНӨААТҮГ-дад улс орон нутгийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг НББОУС-20-ын 15 дугаар зүйлд заасны дагуу “Орлогын арга”-аар бүртгээгүйг эс

тооцвол Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Харин төсвийн байгууллага, ОНӨААТҮГ-ууд санхүүгийн тайлан, тодруулгын иж бүрдлийг хангаж толилуулахгүй байна. **Өөрөөр хэлбэл тодруулга бичдэггүй, толилуулгыг зохистой тодруулаагүй, хөтөлбөр арга хэмжээний хүрсэн үр дүн, танилцуулгын хамт бэлтгээгүй, ур чадвар дутагдаж байна.**

Төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, төсвийн захирагч бүрээр бэлтгэж батлуулаагүй, гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”, 2012 оны 244 дүгээр тушаал “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай”-тай тус тус нийцээгүй байна.

### 3.10.2 Төсвийн бодлогын хэрэгжилт, гүйцэтгэл

Монгол Улсын 2022 оны төсвийн төсөл нь “Хөдөлмөр, бүтээмж, өсөлт” гэсэн гол бодлогод тулгуурлаж зорилтуудаа дэвшүүлсэн бол аймгийн төсвийн бодлогод дараах бодлогыг дэвшүүлэн төсвийг хэлэлцсэн байна. Үүнд:

- Хууль тогтоомжийн хүрээнд төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.
- Татварын үйлчилгээ, татвар төлөлтийг цахимжуулж, хялбаршуулах, хүний хамаарлыг бууруулах, татварын суурийг хамгаалах татварын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.
- Төр өөрийн зардлаа хэмнэх, оновчтой байдлаар дахин хуваарилах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэргээр “БҮХ ШАТНЫ БАЙГУУЛЛАГУУД ХЭМНЭЛТИЙН ГОРИМД” ажиллана.
- Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой чиг үүргийг төр хэрэгжүүлдэг байдлаас татгалзаж СТАНДАРТ-ЧАНАР-ӨРСӨЛДӨӨН-д суурилсан үйлчилгээг төр худалдан авах тогтолцоо /зарчим/-д шилжинэ.
- Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг 2021 оны түвшинд хадгална.

Энэ нь Төсвийн бодлого шинэчлэлийн хүрээнд татварын бүртгэлийг сайжруулж, бааз суурийг нэмэгдүүлэх, шинээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, аймаг сумын иргэдэд сурталчлах, төр өөрийн зардлаа хэмнэх, оновчтой байдлаар дахин хуваарилах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэргээр бүх шатны төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимд ажиллахаар тооцсон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн хэмжээнд 13 төсвийн төвлөрүүлэн захирагч, 59 төсвийн байгууллага, төсөл сан, 17 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, нийт 89 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хамрагдсан.

Сүхбаатар аймгийн төсөвт байгууллага, төсөл сан, ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа байгууллагуудад нийт 277.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 20.2 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 218.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 16 албан шаардлага, дотоод хяналт, үр ашгийг дээшлүүлэх 39.4 сая төгрөгийн 15 зөвлөмж өгсөн.

*Хүснэгт № 12 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн, шийдвэрлэлт /сая.төг/*

№	Хуулийн зүйл	Хязгаарлалт	Тоо	Мөнгөн дүн	Үүнээс					
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн

1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйл	Тэргүүн дэд, дэд, орлогч дарга	3	8.9	3	8.9			
2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл	Тээврийн хэрэгсэл	1	5.6			1	5.6	
3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дугаар зүйл	Албан томилолт	1	1.1	1	1.1			
4	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйл	Цалин хөлс, нэмэгдэл	7	4	1	4.0			6
5	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл	Бусад хангамж	7	24.2	4	2.0	3	22.2	
6	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	9	147.5			9	147.5	
7	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйл	Цахим худалдан авалт	7	40.9			1	9.1	6 31.8
8	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл	Хэмнэлтийн бусад арга хэмжээ	8	45.7	3	4.2	2	33.9	3 7.6
Нийт дүн			43	277.9	12	20.2	16	218.3	15 39.4

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн талаар илэрсэн зөрчил дутагдлын дэлгэрэнгүй мэдээллийг **Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн нэгдсэн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээс үзнэ үү.**

### **3.10.3 Санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх нийцлийн аудитын зарим асуудал**

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Төрийн аудитын байгууллага нь шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхээр заасан.

Тус зохицуулалтын дагуу 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар санал дүгнэлт гаргасан болон түүвэрт хамрагдсан 89 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитаар хослуулан шалгалаа.

Орон нутгийн байгууллагуудын төрийн санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан мэдээллээ Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дутуу мэдээлсэн, мөн хуулийн хугацаа хоцроосон, зарим мэдээллийг огт мэдээлээгүй зөрчил бүхий нийт 19 байгууллагад холбогдох мэдээллийг ил тод байршуулах, зөрчлийг арилгуулах, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага тус тус хүргүүлээ.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу 12 сумдын ИТХ нь нийт 1,803.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөснөөс 1,180.4 сая төгрөг буюу 65.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №13 Малын тоо толгойн татвар /сая төг/

№	Сумдын нэрс	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү		Хувь	
		1		2		/2-1/		/2:1/	
1	Асгат	80.0		48.7		31.3		60.8	
2	Баяндэлгэр	290.3		207.7		82.6		71.5	
3	Дарьганга	181.2		51.8		129.5		28.6	
4	Мөнххаан	145.0		99.7		45.3		68.8	
5	Наран	79.0		62.2		16.8		78.7	
6	Онгон	162.6		88.9		73.7		54.7	
7	Сүхбаатар	210.0		149.3		60.7		71.1	

8	Түвшинширээ	100.0	74.1	25.9	74.1
9	Түмэнцогт	50.0	42.5	7.5	84.9
10	Уулбаян	70.8	39.5	31.3	55.7
11	Халзан	0.0	77.6	-77.6	
12	Эрдэнэцагаан	284.1	139.0	145.1	48.9
13	Баруун-Урт	150.0	99.7	50.3	66.4
	<b>Нийт дүн</b>	<b>1803.0</b>	<b>1180.4</b>	<b>622.6</b>	<b>65.5</b>

Малын тоо толгойн албан татварын орлогын гүйцэтгэл 28.6-84.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд нийт дүнгээрээ 622.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Дээрх гүйцэтгэлээс харахад Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт хангалтгүй хэрэгжиж байгааг харуулж байна. Иймд Малын тоо толгойн албан татварын орлогын биелэлтийг хангуулахад онцгой анхаарах шаардлагатай байна.

### 3.10.4 Аудитын явцад анхаарах бусад асуудал

#### Санхүүгийн тайлангийн аудитын 2021 оны шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл

Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газар нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 54,475.0 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 21,291.3 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан. Залруулаагүй 33,183.7 сая төгрөгийн 597 зөрчилд 373.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 4,663.2 сая төгрөгийн албан шаардлага өгч, 27,983.9 сая төгрөгийн зөрчилд 361 зөвлөмж өгсөн.

Жилийн эцсийн байдлаар 181.1 сая төгрөгийн 13 төлбөрийн акт, 31.2 сая төгрөгийн 6 албан шаардлага, 129.4 сая төгрөгийн 36 зөвлөмж хэрэгжээгүй байна.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 35.8 сая төгрөгийг актыг барагдуулж 145.3 сая төгрөгийн, 6.7 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж 24.5 сая төгрөгийн, 19 зөвлөмжийг хэрэгжүүлж 128.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөн аудитаар нэг албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг албан шаардлагаар хүргүүлсэн ч хэрэгжээгүй үлдэгдэлтэй байна. Биелэлтийг хүснэгтээр харуулбал

Хүснэгт 14. Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

А	Б	Үзүүлэлт	2022 оны жилийн эцсийн үлдэгдэл		2023 оны 01.01-03.31-ны байдлаарх хэрэгжилт		Хэрэгжээгүй үлдэгдэл	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
			3	4	5	6	7	8
1	Төлбөрийн акт	ТТЗ	2	62.5	1	21.6	2	40.9
		ТШЗ	10	112.6	4	14.2	8	98.4
		ТБОНӨААН	1	6	-	-	1	6
		<b>Дүн</b>	<b>13</b>	<b>181.1</b>	<b>5</b>	<b>35.8</b>	<b>11</b>	<b>145.3</b>
2	Албан шаардлага	ТШЗ	5	28.6	1	4.1	4	24.5
		ТБОНӨААН	1	2.6	1	2.6	-	-
		<b>Дүн</b>	<b>6</b>	<b>31.2</b>	<b>2</b>	<b>6.7</b>	<b>4</b>	<b>24.5</b>
		ТТЗ	4	-	1	-	3	-
3	Зөвлөмж	ТШЗ	23	6.9	16	4.1	7	5.6
		ТБОНӨААН	9	122.5	2	-	7	122.5
		<b>Дүн</b>	<b>36</b>	<b>129.4</b>	<b>19</b>	<b>4.1</b>	<b>17</b>	<b>128.1</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар хугацаа хэтэрсэн, хэрэгжээгүй байгаа шийдвэрийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар доор дурдав:

Биелэгдээгүй акт, албан шаардлагыг шүүх, прокурорын байгууллагын туслалцаатайгаар хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Тухайлбал:

Хэрэгжээгүй 18.3 сая төгрөгийн 2 акт, 0.4 сая төгрөгийн 1 албан шаардлагыг шүүхийн байгууллагад шилжүүлсэн.

Төлбөрийн актын үлдэгдэлд малын тоо толгойн албан татварын орлогыг дутуу төвлөрүүлсэн 40.9 сая, хоршоо хөгжүүлэх сангаас авсан иргэд зээлийн гэрээ дуусаж, зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, барагдуулаагүй 83.8 сая төгрөг байгаа нь хэрэгжээгүй байгаа актын 85.8 хувийг эзэлж байна.

Албан шаардлагын үлдэгдэлд хоршоо хөгжүүлэх сангаас авсан иргэд зээлийн гэрээний дагуу зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, барагдуулаагүй 22.4 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Зөвлөмжийн үлдэгдэлд Сүхбаатар нийтлэг ОНӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 93.0 сая төгрөгийн зөвлөмж байна. Уг зөвлөмжийг хэрэгжүүлэхээр Аймгийн ОНӨГ-т албан тоот хүргүүлж, зохих шийдвэрийг гаргуулахаар ажиллаж байна.

Төлбөрийн акт нь аудитад хамрагдагч этгээд буюу хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой тохиолдолд биелэлт удаашрах, шалгагдагч байгууллагаас шүүхэд хандах үед оршин суугаа газрын хаяг тодорхойгүй гэсэн шалтгаанаар шүүх хүлээн авахгүй байх хүндрэл үүсдэг, мөн шалгагдагч байгууллагад ажиллаж байгаа боловч актыг заасан хугацаанд төлж барагдуулахгүй байх зэрэг нөхцөл байдал үүсэж байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөний хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг дарга болон АЗДТГ-ын дарга холбогдох албан хаагч нартай 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хугацаа хэтэрсэн 14 шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахаар уулзалт хийсэн. Үүнээс 3 шийдвэр нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт 2, хариуцлага тооцох албан шаардлага 1 байна.

Уулзалтаар биелэлтийг 2023 оны 01 сарын 27-ны өдрийн дотор албан бичгээр нотлох баримтын хамт ирүүлэх чиглэл өгсөн боловч ирүүлээгүйд 2023 оны 02 сарын 17-ны өдөр ирүүлэх дахин албан тоот хүргүүлсэн бөгөөд ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн онцлох асуудал болон хариуцлага тооцуулах асуудал дээр санал хүргүүлэхээр төлөвлөж байна.

Аудитын шийдвэр бүрэн бус хэрэгжих, хугацаа хэтэрч хэрэгжих, хэрэгжилт удаашрах зэрэг асуудлын шалтгаан нөхцөлийг судалсан бөгөөд аудитын шийдвэрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, тус хэрэгжилттэй холбоотой асуудалд дүн шинжилгээ хийсэн.

### **3.11. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлэх 8 төрлийн мэдээллийг 60 удаа хоцроосон, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг огт мэдээлээгүй, хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

Засаг даргын харьяаны байгууллагуудад шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож, авлага, өр төлбөрийн тайлбар, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нийтлэг зөрчил дутагдал байна.

### **3.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Нийт 7 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмж хэрэгжих шатанд, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

### **3.13. Аудитын зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

**Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг дарга М.Идэрбат, СТСХ-ын дарга Д.Ариунжаргал нарт:**

#### **1. Бүртгэл тайлагналтай холбоотой**

##### **1.1 Илрүүлэлт:**

Бүх шатны байгууллагууд санхүүгийн тайлан, тодруулгын иж бүрдлийг хангаж толилуулахгүй байна. Өөрөөр хэлбэл нягтлан бодогч нарын ур чадвар дутмагаас тодруулга бичдэггүй, толилуулгыг зохистой тодруулаагүй, хөтөлбөр арга хэмжээний хүрсэн үр дүн, танилцуулгын хамт бэлтгээгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

- Нийт нягтлан бодогч нарт санхүүгийн тайлангийн тодруулга, толилуулга бичих талаар сургалт өгч мэдлэг чадварыг дээшлүүлэн, арга зүйн зөвлөмжөөр байнга хангаж байх.

##### **1.2 Илрүүлэлт:**

Сүхбаатар аймагт Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр нийт 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, Улсын төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулсан. Үүний нэг нь МУЗГ болон Азийн хөгжлийн банкны хооронд 2002 оны 09-р сарын 05-ны өдөр байгуулсан “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны MON(SF)-1907”, OL-2301MON-10-тоот гэрээнүүд юм. Уг гэрээний хүрээнд Аймгийн ЗДТГ, Дөрвөлж ОНӨААТҮГ-ын хооронд дамжуулан зээлдүүлэх гэрээ хийгдсэн бөгөөд одоогийн санхүүгийн тайлан дээр толилуулагдсан 4.1 тэрбум төгрөгийн урт хугацаат өр төлбөр байна. Гэтэл 4.2 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн төлбөр, тооцоолсон алданги 25.1 тэрбум төгрөгт хүрсэн талаар мэдэгдэл ирж, тайланд хугацаанд 4.1 тэрбум төгрөгийг ААНОАТ-ын орлогоос суутган тооцуулсан. Цаашид уг зээл төлөгдөх нь тодорхой байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

- Дөрвөлж ОНӨААТҮГ-ын баланс тайланд байгаа урт хугацаат өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, санхүүгийн тайланд тохируулга хийж, баланс тайланд өр төлбөрийг үнэн зөв илэрхийлэх

## **2. Татварын орлого бүрдүүлэлттэй холбоотой:**

### **2.1 Илрүүлэлт:**

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу 12 сумдын ИТХ нь нийт 1,803.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөснөөс 1,180.4 сая төгрөг буюу 65.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт хангалтгүй хэрэгжиж байгааг харуулж байна

#### **Өгсөн зөвлөмж:**

- Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Сумын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, орлогын биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах.

#### **САНАЛ:**

Үндэсний аудитын газрын холбогдох нэгжид дараах саналыг уламжилж байна.

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос 4,183.2 сая төгрөгийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, зээлийн хүүгийн төлбөрт аймгийн Засаг даргын албан тоотын дагуу суутган тооцсон байна. Дээрх дүнгээр Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрхийлэгдсэн эсэхийг анхаарч үзнэ үү.

### 3.14. Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас, Факс: 70512121, 70518232

2023.05.03 № 01/804  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

#### Тайлбар хүргүүлэх тухай

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцаад зарим асуудлууд дээр дараах тайлбарын хүргүүлж байна. Үүнд:

#### 1. Шилэн данстай холбоотой асуудал.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт аймаг, сумдын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт хангалтгүй, холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээлээгүй байгаад дүгнэлт хийж энэ ажлыг сайжруулах, хууль тогтоомжийн шаардлагад хүргэн ажиллах талаар аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Д.Ариунжаргалд үүрэг өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Энэ чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа бөгөөд аймгийн хэмжээний төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарт 04 дүгээр сарын 12- ны сургалт зохион байгуулж Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор гарч байгаа алдаа, мөн мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлэх талаар нарийвчилсан жишээн дээр үндэслэн тайлбарласан сургалтыг тусгайлан хийж зөвлөмж өглөө.

Сумдын ЗДТГ-ын Санхүүгийн албаны үйл ажиллагааны чиглэлийн тодорхойлж, 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар тусгай заалт оруулан гэрээ байгуулсан.

Цаашид Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг сайжруулан төлөвлөгөөний дагуу Санхүү, хяналт аудитын алба болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж үр дүнд хүргэх болно.

2. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх нөхцөлтэй, хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг Аймгийн ИТХ-аар батлуулаагүй шийдвэрлэсэн байна.

Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудаас 2022 оны төсвийн жилд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар 40,968,8 (Дөчин тэрбум есөн зуун жаран найман сая найман зуун) мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд Төсвийн тухай хуульд заасны дагуу 40 хувь болох 16,387,5 (Арван зургаан тэрбум гурван зуун наян долоон сая таван зуун) мянган төгрөг орон нутгийн төсөвт орно гэж тооцсон.

Хууль тогтоомжийн дагуу дээрх орлогыг орон нутгийн төсөвт авах талаар Сангийн яамны холбогдох мэргэжилтэн, хэлтэс, газрын дарга, Төрийн нарийн бичгийн дарга, Сангийн сайдтай хариуцсан хэлтсийн дарга болон аймгийн удирдлагууд удаа дараа биечлэн уулзаж, албан бичиг хүргүүлэн ажилласан. Сангийн яамнаас журмын дагуу төлөвлөсөн хэмжээнд л өгнө, илүүг олгохгүй гэдэг байр сууринаас хандаж хариу өгч байсан.

Олон удаагийн уулзалт, ярилцлагын дүнд 9,637,2 (Есөн тэрбум зургаан зуун гучин долоон сая хоёр зуун) мянган төгрөгийг орон нутгийн төсвийн дансанд авч төсвийн жил дууссан. Төсвийн жил дуустал Сангийн яамнаас албан ёсны хариу өгөөгүй учир ИТХ-аар хэлэлцэх ямар ч боломж гараагүй. (12 дугаар сарын 31-ний орой хүртэл энэ асуудлаар байнга ярьж байсан.)

Төсвийн жил дууссан учир дансаар авах нөхцөл үүсэхгүй болсон, иймээс ААНОАТ-ын үлдэгдлийг аймаг орон нутгийн эрх ашгийн үүднээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн өрөнд суутгуулан тооцох боломжийг эрэлхийлж Сангийн яаманд санал тавьж ярилцсанаар 4,183,2 (Дөрвөн тэрбум нэг зуун наян гурван сая хоёр зуун) мянган төгрөгийг өрөнд суутгуулсан. Хуулийн дагуу орон нутгийн төсөвт орох орлогыг ингээд орхих нь үнэхээр хайран байсан учир Засаг дарга миний хувьд Сангийн яамныхантай тохирч зээлийн өрөндөө суутгуулах нь эцсийн боломжтой хувилбар бөгөөд орон нутагт ч энэ нь ач холбогдолтой байсан. Ямар ч гарцгүйгээр л ийм нөхцөл байдалд хүрсэн. 2023 он гарсан хойно ИТХ-аар нөхөн хэлэлцүүлэх боломжгүй гэдгийг та бүхэн мэдэж байгаа.

Дээрх төлбөрийг 2023 он гарснаас хойш тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан бөгөөд Сангийн яамны зөвлөмж чиглэлийн дагуу тайланд тусгаж тайлагнасан.

Сангийн яамтай олон удаагийн уулзалт, ярилцлага хийж эцсийн байдлаар ойлголцон бөгөөд цаашид энэ асуудал дахин давтагдахгүй гэж үзэж байна.

Аудитын тайланд тусгагдсан алдаа, зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бусад төсвийн захирагчид болон хяналтын байгууллагуудтай хамтран тодорхой ажлуудыг төлөвлөн зохион байгуулж үр дүн, тайланг хүргүүлэн ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА  М.ИДЭРБАТ

**Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:**

**Аймгийн Засаг даргын ирүүлсэн саналд тайлбарыг өгч байна.**

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ
Тайлбар 2	Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй

### 3.15. Аудитын тайлан баталгаажуулсан тушаал:



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/102

Баруун-Урт сум

Аудитын тайланг баталгаажуулах  
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг нэгдүгээр, аудитын шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.


2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Н.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

3. Аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, биелэлтийг 2023 оны 08 сарын 30-ны өдрийн дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Идэрбат), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал)-д зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Н.Болдбаатар), аудитор (Б.Мөнхбамбар) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

D:/Bichig hereg/2023/tushaal



СҮХБААТАР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2022 ОНЫ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД  
ХИЙСЭН АУДИТААР ХҮРГҮҮЛСЭН АЛБАН ШААРДЛАГА

№	Албан шаардлага хүргүүлсэн байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн / сая төгрөг/
1.	Сүхбаатар аймаг Засаг дарга	195А1760374	-
2.	Сүхбаатар аймаг Засаг дарга	196А1760374	-

### 3.16. ХҮРГҮҮЛСЭН АЛБАН ШААРДЛАГА



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 195

11760374

Баруун-Урт сум

СБА-2023/01/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн, хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх нөхцөлтэй, хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг Аймгийн ИТХ-аар батлуулаагүй шийдвэрлэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3-д гурьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх/, 34 дүгээр зүйлийн 34.2-д /Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ/, 64 дүгээр зүйлийн 64.1.2-д /тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх;/ дахь заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “ Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Ариунжаргал нарт даалгав.
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 8 дугаар сарын 30-ны дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
3. Төлбөрийн акт, албан шаардлага хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу хариуцлага тооцно.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

АХЛАХ АУДИТОР

Н.БОЛДБААТАР





СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 196

А1760374 Баруун-Урт сум  
СБА-2023/01/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд: Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс 8 төрлийн мэдээллийг 60 удаа хоцроосон, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/, 6 дугаар зүйлийн 6.1-д /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ/, 6.2-д Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна/, 6.3-д Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна/, 6.4-д / Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ/ дэх заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т " Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой мэдээлж, биелэлтийг 2023 оны 8 дугаар сарын 30-ны дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, СТСХ-ийн дарга Д.Ариунжаргал, Ерөнхий нягтлан бодогч А.Бадмаараг нарт даалгав.
3. Төлбөрийн акт, албан шаардлага хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу хариуцлага тооцно.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ДАВАА  
АХЛАХ АУДИТОР Н.БОЛДБААТАР



## Хавсралтууд

Хавсралт №1

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл жагсаалт

/Сая төгрөгөөр/

Төсвийн захирагчийн ангилал	Нийт зөрчил		Залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох санал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>ТЕЗ</b>	19	74,829.0	14	74,829.0	0	0	2		3			
<b>ТТЗ</b>	15	603.9					2	23.7	13	580.20		
<b>ТШЗ</b>	134	4,550.3	5	122.40	20	58.80	59	4,172.80	48	196.30	2	
<b>ОНӨААТҮГ</b>	51	2,614.4	7	2,172.30	6	8.20	16	417.30	19	16.60	3	
	219	82,579.6	26	77,123.7	26	67.0	79	4613.8	83	793.1	5	0

### Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
1	ТЕЗ	1	1	-	-	1	-	-	-
2	ТТЗ	13	13	-	-	13	-	-	-
3	ТШЗ	59	16	43	-	16	-	-	-
6	ОНӨААТҮГ	21	11	9	-	10	1	-	-
		94	41	52	0	40	1	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил				Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
<b>Төсвийн шууд захирагч</b>										
Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	1	1.9	1	1.9						
Баруун-Урт сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	0.0		0			1			
Мөнххаан сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	8.3		0	1	8.3	1		1	1
Сүхбаатар сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	0.0		0		0	2			
Уулбаян сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	4.2		0		0	2	4.2		
Байгаль орчин аялал жуулчлалын газар	5	102.2	1	1.5	2	100.7	2	0		
Асгат сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	18.6		0	1	18.6	1	0		
Дарьганга сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	53.3		0		0	2	53.3		
Түмэнцогт сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	4.3		0		0	2	4.3		
Онгон сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	22.7		0	1	15	2	7.7		

Эрдэнэцагаан сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	105.5	0	1	92.1	2	13.4
Баяндэлгэр сумын орон нутгийн хөгжлийн сан	1	230.1	0	1	230.1	0	
Түвшинширээ сумын орон нутгийн хөгжлийн сан	1	133.7	0	1	133.7	0	
Халзан сумын орон нутгийн хөгжлийн сан	1	168.0	0	1	168.0	0	
Сүхбаатар аймгийн орон нутгийн хөгжлийн сан	2	275.9	1	30.4	1	245.5	0
Наран сумын Орон нутгийн хөгжлийн сан	6	436.0	0	5	436.0	1	0
Онгон сумын Орон нутгийн хөгжлийн сан	4	433.6	2	4.7	2	428.9	0
Дарьганга сумын Орон нутгийн хөгжлийн сан	4	231.5	0	4	231.5	0	
Түмэнцогт сумын Орон нутгийн хөгжлийн сан	4	358.0	0	2	358	2.00	0
Баруун-Урт сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	358.6	0	2	358.6	0	
Эрдэнэцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сан	8	699.4	3	8.2	5	691.2	0
Асгат сумын орон нутгийн хөгжлийн сан	5	89.4	1	0.9	3	88.5	1
Уулбаян сумын Орон нутгийн хөгжлийн сан	4	9.4	0	1	0	3	9.4
Мөнххаан сумын Орон нутгийн хөгжлийн сан	7	150.3	0	6	150.3	1	0
Сүхбаатар сумын Орон нутгийн хөгжлийн сан	3	0.9	0	2	0.9	1	0
Сүхбаатар сумын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	2.9	0	2	2.9	1	0
Түмэнцогт сумын Засаг даргын тамгын газар	4	47.1	1	4.0	3	43.1	0
Түмэнцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	1.1	3	1.1	0	0	0
Халзан сумын Засаг даргын тамгын газар	1	0.0	0	1	0	0	0
Онгон сумын Засаг даргын тамгын газар	2	0.0	0	0	0	2	0
Ерөнхий боловсролын 4-р сургууль	1	11.9	0	0	0	1	11.9
Уулбаян сумын Засаг Даргын Тамгын Газар	3	0.2	1	0.2	0	2	0
Уулбаян сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	1.1	1	1.1	0	1	0
Дарьганга сумын Засаг даргын тамгын газар	2	0.0	0	1	0	1	0
Дарьганга сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	13.1	1	1.1	0	2	12
Орон нутгийн өмчийн газар	6	9.1	3	2.5	2	6.6	1
Асгат сумын Засаг даргын тамгын газар	2	19.3	1	1.3	1	18	0
Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газар	3	19.1	0	0	2	19.1	1
Мөнххаан сумын Засаг даргын тамгын газар	3	307.3	0	0	1	295.9	2

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар	3	0.0				0	3	0		
Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	31.4			2	31.4		0		
Эрдэнэцагаан сумын Засаг даргын тамгын газар	6	68.7					5	68.7	1	1
Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар	1	0.0			1					
Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газар	1	0.0			1					
<b>Дүн</b>	<b>129</b>	<b>4,427.9</b>	<b>20</b>	<b>58.9</b>	<b>59</b>	<b>4,172.8</b>	<b>48</b>	<b>196.2</b>	<b>2</b>	<b>2</b>
<b>ОНӨААТҮГ</b>										
Баруунурт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ	4	0.0					4			
Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	1	0.0					1			
Наран сумын Молцог илч ОНӨААТҮГ	1	0.0					1			
Халзан-Дулаан ОНӨААТҮГ	4	34.4	1	2.5	1	31.9	2			
Дөрвөлж ОНӨААТҮГ	6	264.1			3	264.1	2		1	1
Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ	2	0.0		0	1	0	1	0.00		
Хайлааст голомт ОНӨААТҮГ	3	10.0		0	2	10	1			
Бичигт Их өргөө ОНӨААТҮГ	1	6.0		0		0	1	6.0		
Чоногол хөгжил ОНӨТҮГ	4	6.2	2	0.5	1	0	1	5.7		
Уртын гэгээ ОНӨААТҮГ	5	36.4	2	4.0	3	32.4		0		
Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ	3	61.9		0	1	57	2	4.9		
Онгон арвижих ОНӨААТҮГ	2	21.9		0	2	21.9				
Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	1	1.3	1	1.3						
Бичигт хөгжил ОНӨААТҮГ	7				2		3		2	2
<b>Дүн</b>	<b>44</b>	<b>442.2</b>	<b>6</b>	<b>8.3</b>	<b>16</b>	<b>417.3</b>	<b>19</b>	<b>16.6</b>	<b>3</b>	<b>3</b>
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагч</b>										
Баруун-Урт сумын Засаг дарга	1	57.8					1	57.8		
Наран сумын Засаг дарга	1	16.8					1	16.8		
Халзан сумын Засаг дарга	1	50.7					1	50.7		
Түмэнцогт сумын Засаг дарга	3	38.6			2	23.7	1	14.9		
Түвшинширээ сумын Засаг дарга	1	122.5					1	122.5		
Уулбаян сумын Засаг дарга	1	31.3					1	31.3		
Эрдэнэцагаан сумын Засаг дарга	1	145.1					1	145.1		
Мөнххаан сумын Засаг дарга	1	67.3					1	67.3		
Сүхбаатар сумын Засаг дарга	1	73.8					1	73.8		
Асгат сумын Засаг дарга	1	0.0					1			
Баяндэлгэр сумын Засаг дарга	1	0.0					1			
Дарьганга сумын Засаг дарга	1	0.0					1			
Онгон сумын Засаг дарга	1	0.0					1			
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>603.9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>23.7</b>	<b>13</b>	<b>580.2</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>										
Аймгийн Засаг дарга	5	0.0			1	0	3	0	1	0



Сүхбаатар аймгийн Чоногол хөгжил ОНӨААТҮГ	1	0.0					1	
Уртын гэгээ ОНӨААТҮГ	1	0.0				1		
СҮХБААТАР НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ	1	0.0				1		
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>5</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>35</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>19</b>	<b>0</b>	<b>16</b>	<b>0</b>
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Наран сумын Засаг даргын Тамгын газар	1	1.1	1	1.1				
Баяндэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	3.3	2	3.3				
Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	3.4	2	3.4				
Уулбаян сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	40.0			2	40.0		
Асгат сумын орон нутгийн хөгжлийн сан	2	10.0			2	10.0		
Мөнххаан сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	87.5			2	87.5		
Сүхбаатар сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	0.0			1			
Сүхбаатар сумын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	0.0			1		1	
Түмэнцогт сумын Засаг даргын тамгын газар	1	0.0					1	
Халзан сумын Засаг даргын тамгын газар	1	9.1			1	9.1		
Уулбаян сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	5.1	1	1.1			1	4.0
Дарьганга сумын Засаг даргын тамгын газар	1	19.2					1	19.2
Эрдэнэцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	2.7					1	2.7
Орон нутгийн өмчийн газар	1	4.0					1	4.0
Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	0.9			1	0.9		
Санхүү хяналт, аудитын алба	1	0.0	1	0.01				
Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газар	1	0.8			1	0.8		
Асгат сумын Засаг даргын тамгын газар	1	0.1	1	0.1				
Мөнххаан сумын Засаг даргын тамгын газар	1	10.0			1	10.0		
Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар	1	5.1	1	5.1				
Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газар	1	0.2	1	0.2				
<b>Дүн</b>	<b>28</b>	<b>203</b>	<b>10</b>	<b>14.3</b>	<b>12</b>	<b>158.3</b>	<b>6</b>	<b>29.9</b>
<b>ОНӨААТҮГ</b>								
Баруунурт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ	1	0.0					1	
Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	1	0.0					1	
Молцог илч ОНӨААТҮГ	1	0.0					1	
Халзан-Дулаан ОНӨААТҮГ	1	0.0					1	
Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ	2	5.6			1	5.6	1	
Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ	1	0.0					1	
Уртын гэгээ ОНӨААТҮГ	2	6.9					2	6.9
СҮХБААТАР НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ	1	2.5					1	2.5
Бичигт хөгжил ОНӨААТҮГ	3	8.8	2	5.8	1	3.0		
Хайлааст голомт ОНӨААТҮГ	2	51.2			2	51.2		
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>75.0</b>	<b>2</b>	<b>5.8</b>	<b>4</b>	<b>59.8</b>	<b>9</b>	<b>9.4</b>
<b>Нийт дүн</b>	<b>43</b>	<b>277.5</b>	<b>12</b>	<b>20.1</b>	<b>16</b>	<b>218.1</b>	<b>15</b>	<b>39.3</b>